БАТЛАВ
БОУАӨЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар

# “ЭРДЭНЭТ ХОТЫН ГАМШИГТ ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Регистрын дугаар 9042113

Хянасан:

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн

______________________________

Боловсруулсан:

“ЭРДЭНЭТ ХОТЫН ГАМШИГТ ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ” төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн Байгаль орчны мэргэжилтэн

С.Нансалмаа

Эрдэнэт хот 2025 он

# Агуулга


Хүснэгтийн жагсаалт ... 1

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 2

1. Төслийн товч танилцуулга ... 2
1.1. Төслийн талаарх ерөнхий мэдээлэл ... 2
1.2. Үерээс хамгаалах ажил ... 2
1.2.1. Цөөрөм ... 3
1.2.2. Суваг ... 4
1.2.3. Барилгын ажлын төлөвлөгөө ... 8
1.3. Гэр хорооллын усан хангамжийн сүлжээг өргөтгөх. Нэмэлтээр хотын төвийн усан хангамжийн сүлжээг сэргээн засварлах/сайжруулах ажил ... 9
1.3.1. Ажлын цар хүрээ ... 9
1.3.2. 2025 онд хэрэгжүүлэх барилгын ажлын төлөвлөгөө ... 18
1.4. Төслийн ач холбогдол ... 18

2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт ... 19
2.1. Газар зүйн байрлал, газрын гадарга: ... 19
2.2. Цаг уур, уур амьсгал ... 19
2.2.1. Агаарын даралт: ... 20
2.2.2. Агаарын температур: ... 20
2.2.3. Агаарын чийгшил: ... 20
2.2.4. Хур тунадас: ... 20
2.3. Гадаргын ба газрын доорх усны өнөөгийн төлөв байдал ... 20
2.4. Хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдал ... 20
2.8. Нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал ... 21
2.9. Түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдал ... 22

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт ... 22
3.1. Газрын гадарга, хэвлий: ... 22
3.2. Агаарын чанар: ... 22
3.3. Гадаргын ус: ... 22
3.4. Газар доорх ус: ... 23
3.5. Хөрсөн бүрхэвч: ... 23
3.6. Ургамлан нөмрөг: ... 23
3.7. Амьтны аймаг: ... 23
3.8. Нийгэм, эдийн засаг: ... 23
3.9. Тусгай хамгаалалттай газар нутаг: ... 24

4. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ... 24
4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт ... 24
4.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 25
4.2.1. Агаар ... 25
4.2.2. Газрын гадарга хэвлий ... 27
4.2.3. Усан орчин ... 28
4.2.4. Хөрс ... 31
4.2.5. Биологийн төрөл зүйл ... 33
4.2.6. Нийгэм-эдийн засаг, иргэдийн оролцоо ... 35

4.3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ....................................39
4.4. ОСОЛ, ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .......................44
4.4.1.Үйлдвэрлэлийн осол эрсдэл.......................................................................................44
4.4.2. Байгалийн гамшиг.....................................................................................................48
4.5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ...................................................51

5. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР..................................................55
5.1. Агаарын чанар.................................................................................................................55
5.2. Дуу шуугиан....................................................................................................................56
5.3. Гадаргын усны чанар.......................................................................................................56
5.4. Хөрсний чанар..................................................................................................................56
5.5. Ургамлан нөмрөг...............................................................................................................58

6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.................................................60

7. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ...............61

# Зургийн жагсаалт

Зураг 1. Ерөнхий байршил ....3
Зураг 2. Цөөрмийн зүсэлт ....4
Зураг 3. Сувгийн байршил ....5
Зураг 4. Ерөнхий байршил ....10
Зураг 5. Ус түгээх 57 дугаар киосктой холбох байршил ....11
Зураг 6. Ус түгээх 18 дугаар киосктой холбох байршил ....11
Зураг 7. Наран багийг бохирын шугамд холбох байршил ....12
Зураг 8. Говил багийн цэвэр усны шугамыг шинэчлэх байршил ....13
Зураг 9. Бүрэнбүст багт орших шугам сүлжээний байршил ....14
Зураг 10. Уурхайчин багт орших шугам сүлжээний байршил ....15
Зураг 11. Баянцагаан багт орших шугам сүлжээний байршил ....16
Зураг 12. UDDT- 4-2 Шугам сүлжээг солих байршил ....17
Зураг 13. Газрын нэгдмэл санд ээлэх хувь ....19

# Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Цөөрмийн ерөнхий мэдээлэл ....4
Хүснэгт 2. Сувгийн хүчин чадал ....6

# БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 1. Төслийн товч танилцуулга

### *1.1. Төслийн талаарх ерөнхий мэдээлэл*

"Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төсөл нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын төвд буюу Эрдэнэт хотод хэрэгжинэ.

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар нь Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр Эрдэнэт хотод дараах 2 төрлийн ажлыг гүйцэтгүүлэхээр Престиж инженеринг ХХК, Хунан индустриал ХХК-тай гэрээ байгуулаад байна. Үүнд:

- Үерээс хамгаалах ажил /үерийн хамгаалалтын суваг, ус хуримтлуулах байгууламж шинэчлэх, байгуулах/.
- ус хангамжийн шугам хоолой, бохирын /ариутгах татуургын/ шугам хоолойг шинээр барих, шинэчлэн солих.

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ) болон МУ-ын Засгийн Газар хооронд байгуулсан зээлийн гэрээний хүрээнд Орхон аймагт дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Орхон аймгийн Баян-Өндөр сум буюу Эрдэнэт хотын үерийн хамгаалалтын дэд бүтцийг шинэчлэх, өргөтгөх мөн цэвэр усны сүлжээг сайжруулах зорилгоор энэхүү төслийг боловсруулсан болно.

### *1.2. Үерээс хамгаалах ажил*

Ажлын хүрээнд Монгол Улсын Эрдэнэт хотын үерийн аюулаас урьдчилан сэргийлэх байгууламжийн (суваг, Цөөрөм) барилгын  ажлын зураг, барилга угсралтын ажил багтсан болно.Уг ажилд 4 ус хадгалах цөөрөм (1-ээс 4) болон 8 суваг (А-аас H) багтсан бөгөөд доорх зургийг үзнэ үү.

Ус хадгалах цөөрмүүдэд нэг метрийн өндрийн интервалтай контурын дагуу 1½ метр өндөртэй шороон далан байгуулна. Эдгээр цөөрмүүд нь тэгш гадаргуу бүхий газруудад байрлана. Цөөрмийн усны хамгийн их гүн нь нэг метр байна. Цөөрмүүдийн хэсэг бүрээс бетонон гаралт ба халилтын сувгаар усыг гаргана.

Цөөрмийн дотор тал элэгдэлд орохоос сэргийлж бетонон суваг байгуулна. Хот дундуур байх сувгийн сонгосон хэсгийг ус дамжуулах чадварыг нэмэгдүүлэх болон элэгдэлд оруулахгүйн тулд бетонон доторлогоотой хийнэ. Сувгийн хэмжээсүүд нь тооцооноос хамааран өөр өөр байх болно. Гүн нь 1-2 метр, ёроолын өргөн нь 1-8 метрийн хооронд хэлбэлзэнэ. Сувгийн хажуу талууд нь босоо эсвэл 1:2 налуутай байна. Сувгуудын нийт урт нь ойролцоогоор 12 км.

*Зураг 1. Ерөнхий байршил*




### 1.2.1. Цөөрөм

Нийт 4 борооны ус хадгалах цөөрөм барих ба эдгээр нь өндөрлөг газарт 3, Эрдэнэт голын хөндийд 1 байна. 3 цөөрмийг хүн амын суурьшлын дээд хэсэгт барих бөгөөд тэдгээрийн зориулалт нь аадар борооны үед урсгалын доод талын сувгийн ачааллыг хөнгөвчлөх явдал юм.

Ландшафтын байгалийн элемент болгож, өндөр далан үүсэх эрсдэлээс зайлсхийж ус хадгалах цөөрмийг каскадын систем дэх намхан шороон далангаар хийнэ. Далан нь контурыг дагаж, нэг захаас нөгөө зах хүртэл ижил өндөртэй байх ёстой. Өндөр нь дээд талдаа 1.5 метр, доод талдаа 2.5 метр байна. Далан барих материалыг далангийн хоорондох хэсгээс авч ашиглана.

Элэгдлээс хамгаалах зорилгоор цөөрмийн дундуур намхан талтай бетонон суваг байгуулна. Суваг даланг дайран өнгөрөх газарт урсацыг зохицуулж, усны тодорхой хэсгийг барьж байх үүднээс бетонон гаралт ба халилтын суваг хийнэ. Уг гаралтын суваг нь Монгол Улсын стандартын дагуу 100 жилд хамгийн их хур бороотой үед цөөрөмд 1 метр орчим ус хураагдахаар төлөвлөгдсөн байна.

Хур борооны мэдээллээр зуун жилд нэг удаа тохиолддог аадар борооны нөхцөлийг хангахын тулд далан бүрт халих байгууламж байгуулна.

Дөрвөн цөөрмийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгт 1-д үзүүлэв.

*Хүснэгт 1. Цөөрмийн ерөнхий мэдээлэл*

| Цөөрмийн дугаар. | 1 | 2 | 3 | 4 (Нуур) |
|---|---|---|---|---|
| **Гадаргуугын талбай, м2** | 11000 | 27000 | 28500 | 18000 |
| **Хадгалах хэмжээ, м3** | 10500 | 25500 | 27000 | |
| **Далангийн урт, м** | 350 | 800 | 875 | 90 |
| **Сувгын урт, м** | 130 | 170 | 280 | |
| **Дундаж хэвгий, 0/00** | 17 | 22 | 15 | |
| **Макс. урсгал, Монгол улсын стандарт, м3/с** | 5,5 | 10,5 | 4 | |
| **Макс. урсгал, борооны мэдээлэл, м3/с** | 18 | 26 | 10 | |

Доорх зураг нь цөөрмийн дагуугын зүсэлтийг харуулав.

*Зураг 2. Цөөрмийн зүсэлт*




### *1.2.2. Суваг*

Энэ сувгууд нь одоогийн байгалийн усны урсгалтай харьцуулахад илүү их хүчин чадалтай байх ёстой.

Сувгийн трасс нь одоо байгаа зам дагуу болон ногоон байгууламжаар дамжина. Уг төсөлд хамаарах сувгуудыг доорх зураг 3-т үзүүлэв.

*Зураг 3. Сувгийн байршил*




Сувгийн хэмжээсүүд нь тооцооны урсгалаас хамааран өөр өөр байх болно. Гүн нь 1-2 метр, ёроолын өргөн нь 1-8 метрийн хооронд хэлбэлзэнэ.

Сувгийн хажуу талууд нь босоо байх эсвэл 1:2 налуутай байна. Доорх хүснэгтэд сувгийн хүчин чадал, хэмжээсийн талаархи тойм мэдээлэл өгсөн болно.

Дэлгэрэнгүйг хүснэгт 2-оос харна уу.

*Хүснэгт 2. Сувгийн хүчин чадал*

| Channel name | Approx. Length, (m) | Channel gradient (m/m) | Depth, (m) | Bottom width, (m) | Top width, (m) | Slope of sides, (m/m) | Wall above ground level, (m) | Necessary capacity, (m3/s) | Material C (concrete), RR (rip-rap) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 200 | 0,005 | 1,50 | 2,50 | 2,50 | 0 | 0-0,5 | 12,0 | C |
| | 560 | 0,006 | 1,50 | 2,50 | 2,50 | 0 | 0-0,5 | 12,0 | C |
| | 20 | 0,030 | 1,00 | 2,50 | 2,50 | 0 | | 12,0 | C |
| | 320 | 0,006 | 1,50 | 2,50 | 2,50 | 0 | 0-0,5 | 12,0 | C |
| | 20 | 0,041 | 1,00 | 2,50 | 2,50 | 0 | | 12,0 | C |
| | 380 | 0,002 | 2,00 | 3,00 | 3,00 | 0 | 0,5 - 1,0 | 12,0 | C |
| | 40 | 0,002 | 2,00 | 3,00 | 3,00 | 0 | | 12,0 | C |
| | 156,4 | 0,002 | 2,00 | 3,00 | 3,00 | 0 | | 12,0 | C |
| B | 310 | 0,005 | 1,50 | 1,00 | 2,50 | 0,5 | | 4,0 | C |
| | 50 | 0,010 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 5,0 | C |
| | 210 | 0,021 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 5,0 | C |
| | 350 | 0,006 | 1,20 | 1,00 | 2,20 | 0,5 | | 5,0 | C |
| | 224 | 0,007 | 1,20 | 1,00 | 2,20 | 0,5 | | 5,0 | C |
| C | 160 | 0,013 | 2,00 | 2,00 | 4,00 | 0,5 | | 15,0 | R |
| | 400 | 0,005 | 2,00 | 2,50 | 4,50 | 0,5 | | 15,0 | R |
| | 40 | 0,019 | 2,00 | 2,50 | 4,50 | 0,5 | | 25,0 | R |
| | 600 | 0,019 | 2,00 | 2,00 | 4,00 | 0,5 | | 25,0 | R |
| | 780 | 0,013 | 2,00 | 2,50 | 4,50 | 0,5 | | 25,0 | R |
| | 20 | 0,005 | 1,50 | 5,00 | 5,00 | 0,0 | | 25,0 | C |
| | 100 | 0,003 | 2,00 | 2,50 | 4,50 | 0,5 | | 25,0 | R |
| | 280 | 0,013 | 2,00 | 2,50 | 4,50 | 0,5 | | 25,0 | R |
| | 378 | 0,008 | 2,00 | 3,00 | 5,00 | 0,5 | | 25,0 | R |
| | 20 | 0,008 | 1,50 | 5,00 | 5,00 | 0,0 | | 25,0 | C |
| | 14 | 0,008 | 2,00 | 3,00 | 5,00 | 0,5 | | 25,0 | R |
| D | 460 | 0,004 | 1,50 | 3,00 | 4,50 | 0,5 | | 18,0 | C |
| | 140 | 0,002 | 1,50 | 4,00 | 5,50 | 0,5 | | 18,0 | C |
| | 700 | 0,002 | 2,00 | 8,00 | 8,00 | 0,0 | | 49,0 | C |
| | 400 | 0,006 | 2,00 | 8,00 | 8,00 | 0,0 | | 49,0 | C |
| | 108 | 0,006 | 2,00 | 8,00 | 8,00 | 0,0 | | 49,0 | C |
| | 250 | Increase height of exist. walls with 0,5 meter | | | | | | 49,0 | C |
| E | 180 | 0,057 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 5,0 | R |
| | 500 | 0,037 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 5,0 | R |
| | 200 | 0,037 | 1,10 | 1,50 | 2,60 | 0,5 | | 9,0 | R |
| | 80 | 0,060 | 1,10 | 1,50 | 2,60 | 0,5 | | 9,0 | R |
| | 60 | 0,034 | 1,20 | 1,50 | 2,70 | 0,5 | | 12,0 | R |
| | 22 | 0,030 | 1,20 | 1,50 | 2,70 | 0,5 | | 12,0 | C |
| | 278 | 0,034 | 1,20 | 2,00 | 3,20 | 0,5 | | 12,0 | R |
| | 460 | 0,042 | 1,20 | 2,00 | 3,20 | 0,5 | | 12,0 | R |
| | 68 | 0,007 | 1,50 | 3,00 | 4,50 | 0,5 | | 12,0 | R |
| F | 120 | 0,100 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 40 | 0,075 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 160 | 0,092 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 40 | 0,107 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 60 | 0,092 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 80 | 0,082 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 40 | 0,062 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 60 | 0,084 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 40 | 0,075 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 120 | 0,067 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 80 | 0,076 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 40 | 0,125 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 3,0 | R |
| | 120 | 0,050 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 6,0 | R |
| | 60 | 0,067 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 6,0 | R |
| | 100 | 0,040 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 6,0 | R |
| | 40 | 0,067 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 6,0 | R |
| | 100 | 0,064 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 6,0 | R |
| | 132 | 0,058 | Buried culvert, internal dimension 0,7x1,5 met | | | | | 6,0 | C |
| G | 140 | 0,039 | 1,00 | 2,00 | 3,00 | 0,5 | | 9,8 | R |
| | 100 | 0,029 | 1,00 | 2,00 | 3,00 | 0,5 | | 9,8 | R |
| | 160 | 0,040 | 1,00 | 2,00 | 3,00 | 0,5 | | 9,8 | R |
| | 100 | 0,026 | 1,10 | 2,00 | 3,10 | 0,5 | | 9,8 | R |
| | 20 | 0,075 | 1,00 | 2,00 | 3,00 | 0,5 | | 9,8 | C |
| | 80 | 0,014 | 1,30 | 2,00 | 3,30 | 0,5 | | 9,8 | R |
| | 20 | 0,039 | 1,30 | 2,00 | 3,30 | 0,5 | | 9,8 | C |
| | 140 | 0,030 | 1,30 | 2,00 | 3,30 | 0,5 | | 9,8 | R |
| | 20 | 0,070 | 1,30 | 2,00 | 3,30 | 0,5 | | 9,8 | C |
| | 120 | 0,028 | 1,30 | 2,00 | 3,30 | 0,5 | | 9,8 | R |
| | 160 | 0,016 | 1,30 | 2,00 | 3,30 | 0,5 | | 9,8 | R |
| | 35 | | Existing culvert under main road | | | | | 13,6 | |
| | 5 | 0,500 | 1,30 | 2,00 | 3,30 | 0,5 | | 13,6 | R |
| | 80 | 0,031 | 1,30 | 3,00 | 4,30 | 0,5 | | 13,6 | R |
| | 120 | 0,029 | 1,30 | 3,00 | 4,30 | 0,5 | | 13,6 | R |
| | 200 | 0,023 | 1,30 | 3,00 | 4,30 | 0,5 | | 13,6 | R |
| | 137 | 0,011 | 1,30 | 3,00 | 4,30 | 0,5 | | 13,6 | R |
| H | 260 | 0,033 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 1,5 | R |
| | 286 | 0,010 | 1,00 | 1,00 | 2,00 | 0,5 | | 1,5 | R |

Сувгууд нь элэгдэлд орохоос хамгаалахын тулд угсармал бетон хавтан эсвэл rip-rap (бетонд суулгасан чулуу) доторлогоотой байна.

Сувгийн материал нь сувгийн хүчин чадалд ихээхэн нөлөөлдөг. Бетон хавтанг тодорхойлсон тохиолдолд түүнийг rip-rap болгон өөрчлөх боломжгүй, учир нь энэ нь сувгийн хүчин чадлыг бууруулдаг. Хэрэв rip-rap гэж заасан бол түүнийг бетонон хавтан болгон өөрчилж болох боловч суваг дахь усны урсацын аюултай өндөр хурднаас зайлсхийхийн тулд усны урсац сааруулагч хийх шаардлагатай байдаг.

Бүх ус дамжуулах хоолой нь сувгийн багтаамжтай ижил багтаамжтай байх ёстой бөгөөд энэ нь бөглөрөл үүсгэхгүй байх ёстой. Ус дамжуулах хоолойг гүүрээр сольж болно .

Зарим сувгуудыг үерлэж халихаас сэргийлж, хангалттай багтаамжтай байлгахын тулд ханыг нь, өөрөөр хэлбэл сувгийн хажуу талыг нь газрын түвшнээс дээш гаргаж хийх шаардлагатай байдаг. Үүнийг холбогдох хүснэгтийн "Газрын түвшнээс дээших хана" гэсэн баганад тайлбарласан болно.

D сувгийн төгсгөлд байгаа сувгийн ханын өндрийг 50 см-ээр нэмэгдүүлнэ. Одоо байгаа сувгийн урт нь ойролцоогоор 250 метр юм.

А сувгийн дэд хэсэгт сувагт зай гаргахын тулд явган хүний замыг (900 метр) замын нөгөө тал руу шилжүүлэх шаардлагатай.

### 1.2.3. Барилгын ажлын төлөвлөгөө

| | Ажилбарууд | он | 2025 он | | | | | | | | | | | 2026 он | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сар | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 1 | Дэлгэрэнгүй зураг төсөл | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Дэлгэрэнгүй зураг төсөл батлуулах | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Бэлтгэл ажлын хугацаа | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Суваг B 1-4 далан & усан сан төлөвлөлт, суурийн нүх ухах, далангийн барилга барих, тэгшлэх болон нягтруулах, арматур уях болон хэв хашмалын тулгуур, бетон цутгах, чулуун бэхэлгээ хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Суваг C 1-5 далан төлөвлөлт, суурийн нүх ухах, далангийн барилга барих, тэгшлэх болон нягтруулах, арматур уях болон хэв хашмалын тулгуур, бетон цутгах, чулуун бэхэлгээ хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Суваг A төлөвлөлт, суваг шуудуу ухах, Тэгшлэх, дарах, урьдчилан угсрах суурилуулах, булалт ба нягтруулалт хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Суваг B төлөвлөлт, суваг шуудуу ухах, Тэгшлэх, дарах, урьдчилан угсрах суурилуулах, булалт ба нягтруулалт хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 8 | Суваг C төлөвлөлт, суваг шуудуу ухах, Тэгшлэх, дарах, урьдчилан угсрах суурилуулах, булалт ба нягтруулалт хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 9 | Суваг D төлөвлөлт, суваг шуудуу ухах, Тэгшлэх, дарах, урьдчилан угсрах суурилуулах, булалт ба нягтруулалт хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 10 | Суваг E төлөвлөлт, суваг шуудуу ухах, Тэгшлэх, дарах, урьдчилан угсрах суурилуулах, булалт ба нягтруулалт хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 11 | Суваг F төлөвлөлт, суваг шуудуу ухах, Тэгшлэх, дарах, урьдчилан угсрах суурилуулах, булалт ба нягтруулалт хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 12 | Суваг 6 төлөвлөлт, суваг шуудуу ухах, Тэгшлэх, дарах, урьдчилан угсрах суурилуулах, булалт ба нягтруулалт хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 13 | Суваг H төлөвлөлт, суваг шуудуу ухах, Тэгшлэх, дарах, урьдчилан угсрах суурилуулах, булалт ба нягтруулалт хийх | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |

### *1.3. Гэр хорооллын усан хангамжийн сүлжээг өргөтгөх. Нэмэлтээр хотын төвийн усан хангамжийн сүлжээг сэргээн засварлах/сайжруулах ажил*

#### *1.3.1. Ажлын цар хүрээ*

Энэхүү ажлын хүрээнд гэр хорооллын усан хангамжийн шугам сүлжээг өргөтгөх, Эрдэнэт хотын төвийн усан хангамжийн шугам сүлжээг шинэчлэх, сайжруулах зэрэг ажлууд багтсан болно.

Эрдэнэт ус компани нь хотын нийт иргэдийн 40 хувийг цэвэр усаар хангадаг. Хотын үлдсэн хэсэг нь гэр хороололд амьдардаг бөгөөд иргэд Эрдэнэт ус компаниас усаар хангадаг 79 ус түгээх киоскоос усаа авдаг.

Ажил дараах хэсгээс бүрдэнэ:

**А. Гэр хорооллын холболт**

- Ажил 1. Ус түгээх 57 дугаар киосктой холбох
- Ажил 2. Ус түгээх 18 дугаар киосктой холбох
- Ажил 3 Наран хорооллыг бохирын шугамд холбох
- Ажил 4, Говилын цэвэр усны шугамыг шинэчлэл

**В. Хотын усан хангамж**

- Ажил 5. Бүрэнбүст
- Ажил 6. Уурхайчин
- Ажил 7. Баянцагаан
- Ажил 8 UDDT- 4-Сүлжээ солих

Ажил 1 ба 2-т ус түгээх цэгүүд, холбогдох хавхлагууд, холбох хэрэгслүүдтэй холбох шинэ усны шугамууд орно. Наран хорооллын бохирын шугамын холболтыг дуусгах ажил 3-т шугам хоолой, худгийн нүх, холбогдох бүх холбох хэрэгсэл шаардлагатай.

Ажил 3-т төсвөөс хамааруулан оруулах сонголтоор нэмж оруулсан болно.

Ажил 4, 5, 6, 7-г одоо байгаа шугам хоолойг нөхөн сэргээхэд оршиж байгаа юм. Угтаа энэ нөхөн сэргээлт нь эдгээр газруудад байгаа шугам хоолойг солих юм. Гүйцэтгэгчийг одоо байгаа шугам хоолойг зайлуулах эсвэл газар дээр нь үлдээж, шинэ шугамыг зэрэгцүүлэн тавих болно.

Ажил 8 нь халуун усны зэвэрсэн хоолойг солих явдал юм.

*Зураг 4. Ерөнхий байршил*




Таних тэмдэг:
Ажил 1. Ус түгээх 57 дугаар киосктой холбох
Ажил 2. Ус түгээх 18 дугаар киосктой холбох
Ажил 3 (Сонголт 2). Наран хорооллыг бохирын шугамд холбох
Ажил 4, Говилын цэвэр усны шугамыг шинэчлэл
Ажил 5. Бүрэнбүст
Ажил 6. Уурхайчин
Ажил 7. Баянцагаан
Ажил 8 (Сонголт 1). UDDT- 4-2 Сүлжээ солих

## Ажил 1: Ус түгээх 57 дугаар киосктой холбох

Даваат багт орших 2-8-р сарын хооронд хөлдөж, усгүй болгож байсан 57 дугаар коискийн цэвэр усны шугамыг шинэчилнэ.

Ус дамжуулах шугамыг анх 2015 онд барьсан ч асуудал байсаар байна.

*Зураг 5. Ус түгээх 57 дугаар киосктой холбох байршил*




## Ажил 2: Ус түгээх 18 дугаар киосктой холбох

Шанд багт орших 18 дугаар ус түгээх киоскын цэвэр усны шугам мөнх цэвдэгтэй тул хөлдөж, ашиглалтаас гарсан. Үүний улмаас шугамыг дулаалгатай хоолойгоор солих шаардлагатай байна. Шугам хоолойг 2016 онд барьж дуусгасан ч жил бүр асуудал байсаар байна.

*Зураг 6. Ус түгээх 18 дугаар киосктой холбох байршил*



Ажил 3: Наран багийг бохирын шугамд холбох

The manhole cover cannot be completed due to the traffic on the street, so it is planned to be 10 cm high in the middle so as not to impede traffic. Наран багийн 27 болон 26 дугаар kioskийн бохирын шугамыг шинээр татна. Уртаашаараа зөвшөөрөгдөх нормоор нүхний хоорондох зай 35 м-ээс хэтрэхгүй байх ёстой (SW -1-ээс SW -10 хүртэлх 10 худаг (одоогоор 2 цооног байгаа). Гэр хорооллын доторх гудамж тул хөрс нь нягтаршсанд тооцогддог. Гудамжинд хөл хөдөлгөөн ихтэй байгаа тул нүхний тагийг хийж дуусгах боломжгүй тул замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож, дунд хэсэгт нь 10 см өндөртэй байхаар төлөвлөжээ.

*Зураг 7. Наран багийг бохирын шугамд холбох байршил*



Ажил 4: Говил багийн цэвэр усны шугамыг шинэчлэх

Усан хангамжийн шугамын ашиглалтын хугацаа дуусч, ус алдалт ихтэй байгаа тул шинэчлэх шаардлагатай байна. Дамжуулах хоолойг 1980 онд ашиглалтад оруулсан.

*Зураг 8. Говил багийн цэвэр усны шугамыг шинэчлэх байршил*



# ХОТЫН УС ХАНГАМЖИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ

## Ажил 5: Бүрэнбүст

Шугам хоолойг 1986 онд барьсан бөгөөд 2012 оноос хойш хоолой олон удаа хагарсан. Уртын дагуу олон цооног өрөмдөж, шугам хоолойг хэсэгчлэн таслах, засах боломжгүй болгосон. Шугам хоолойн байршлыг тогтоосон бөгөөд шугам хоолойн дагуу 12 танхим /chamber/-тай.

2 танхим /chamber/-д нь галын цорго суурилуулсан байна. Дамжуулах хоолойн одоогийн диаметр нь Ф200 мм.

*Зураг 9. Бүрэнбүст багт орших шугам сүлжээний байршил*



## Ажил 6: УУРХАЙЧИН БАГ

Уурхайчин багт орших шугам сүлжээ нь 1978 онд баригдсан бөгөөд уг шугам нь ойр ойрхон хагарсан, мөн их хэмжээний ус алдагдахаас сэргийлж яаралтай сэргээн засварлах шаардлагатай болсон.

*Зураг 10. Уурхайчин багт орших шугам сүлжээний байршил*



## Ажил 7: Баянцагаан

Баянцагаанд орших шугам сүлжээ нь 1978 онд баригдсан бөгөөд хивсний үйлдвэр, цагдаа, онцгой байдлын хэлтэс, хүнс, сүү боловсруулах үйлдвэр зэрэг байгууллага, үйлдвэрүүдийг усаар хангах зориулалттай. Хоолой нь байнга дэлбэрдэг, их хэмжээний ус гоожиж эрчдэлтэй тул яаралтай нөхөн сэргээх/солих шаардлагатай болсон.

*Зураг 11. Баянцагаан багт орших шугам сүлжээний байршил*



Ажил 8 (сонголт 1): UDDT- 4-2 Шугам сүлжээг солих

Халуун ус дамжуулах шугамуудын ашиглалтын хугацаа дуусч, маш их зэвэрсэн тул солих шаардлагатай

*Зураг 12. UDDT- 4-2 Шугам сүлжээг солих байршил*



### *1.3.2. 2025 онд хэрэгжүүлэх барилгын ажлын төлөвлөгөө*

| | **Ажилбарууд** | **он** | **2024 он** | | **2025 он** | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **сар** | **11** | **12** | **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** | **10** | **11** | **12** |
| 1 | **Барилгын өмнөх үе шат** | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Ажлын зураг төсөл | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Түр байрны газрын зөвшөөрөл | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Байгууллагын бүтэц, харилцааны матриц | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Барилгын байгаль орчин, Нийгмийн удирдлагын төлөвлөгөө | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөө | | | | | | | | | | | | | | | |
| 8 | Чанарын баталгааны болон хяналтын төлөвлөгөө | | | | | | | | | | | | | | | |
| 9 | Замын хөдөлгөөний хяналтын төлөвлөгөө | | | | | | | | | | | | | | | |
| 10 | Түр байрны төлөвлөгөө | | | | | | | | | | | | | | | |
| 11 | Ажлын аргачлал | | | | | | | | | | | | | | | |
| 12 | Үйлдвэрлэгчийн мэдээлэл | | | | | | | | | | | | | | | |
| 13 | **Бэлтгэл ажил** | | | | | | | | | | | | | | | |
| 14 | Ажил олгогчийн ажлын зөвшөөрөл | | | | | | | | | | | | | | | |
| 15 | Ажил эхлэх огноо | | | | | | | | | | | | | | | |
| 16 | Талбайн бэлтгэл | | | | | | | | | | | | | | | |
| 17 | Ажиллах хүч, техник хэрэгслийн шилжүүлэг | | | | | | | | | | | | | | | |
| 18 | Материал талбайд хүргэх | | | | | | | | | | | | | | | |
| 19 | **Барилгын ажил** | | | | | | | | | | | | | | | |
| 20 | Багц 1 | | | | | | | | | | | | | | | |
| 21 | Улаан шугам татах | | | | | | | | | | | | | | | |
| 22 | Байршил 1 - Киоск 57 | | | | | | | | | | | | | | | |
| 23 | Байршил 2 - Киоск 18 | | | | | | | | | | | | | | | |
| 24 | Байршил 4 - Гови | | | | | | | | | | | | | | | |
| 25 | Багц 2 | | | | | | | | | | | | | | | |
| 26 | Байршил 7 - Баянцагаан | | | | | | | | | | | | | | | |
| 27 | Байршил 8 - Дүүрэг 4 | | | | | | | | | | | | | | | |
| 28 | **Хүлээн авах үе шат** | | | | | | | | | | | | | | | |

### *1.4. Төслийн ач холбогдол*

Энэхүү төсөл хэрэгжснээр, үер усны аюул 40-50 хувь буурах бөгөөд ойролцоогоор 11,000 оршин суугчид найдвартай аюулгүй ундны усны сүлжээнд холбогдох болно. Төслийн хүрээнд хийгдэх ажлын үр дүнд системийн усны алдагдал 15 хувиар буурах боломжтой.

# 2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

### *2.1. Газар зүйн байрлал, газрын гадарга:*

Орхон аймаг нь геоморфологийн мужлалтын хувьд Төв Азийн геоморфологийн мужид, Орхон-Сэлэнгийн мужийн Сэлэнгийн дэд мужид дундаж өндөр уул ба нам уулын хэв шинжид хамаарна.

Орхон аймаг нь Монгол орны томоохон гол мөрөн болох Орхон-Сэлэнгийн сав газрын далайн түвшнээс дээш 1000-1711 м (дундаж 1200 м) өндөрт өргөгдөн орших ба ерөнхийдөө бэсрэг уулс зонхилдог. Хамгийн өндөр цэг нь нутгийн төв хэсэгт орших Согоот уул 1711 метр үнэмлэхүй өндөртэй, нам цэг нь Тохой гэдэг газар 950 м орчим өндөртэй. Уулс ихтэй, гуу, жалга, сархиаг ихтэй, шинэс, нарс, хус, хуш, улиас зэрэг модлог ургамалтай. Зүүн талаараа Сэлэнгэ, баруун талаараа Булган аймагтай хиллэн оршдог.

Аймгийн газар нутгийн хэмжээ 84400 га ба энэ үзүүлэлтээрээ Монгол орны хамгийн жижиг газар нутагтай аймагт тооцогдоно. Нийт нутаг дэвсгэрийн газрын нэгдмэл сангийн ангиллаар 46281 га нь хөдөө аж ахуйн газарт, 20616 га нь хот, тосгоны суурин газарт, 1256 га нь зам, шугам сүлжээний газарт, 15884 га ойн сан бүхий газарт, 361 га нь бусад ангилалд багтана /Зураг 1/.

*Зураг 13. Газрын нэгдмэл санд эзлэх хувь*




### *2.2. Цаг уур, уур амьсгал*

Нутгийн цаг агаар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай боловч газарзүйн байршлын онцлог болон газар нутгийн хотгор гүдгэрийн байдал нь хотын бичил уур амьсгал бүрдүүлэх үндсэн нөхцөл болж дулааны улиралд сэрүүвтэр, хүйтний улиралд харьцангуй дулаавтар, хавар, намрын улиралд салхи шуурга ихэсч хуурайшилтын зэрэг, агаарын температурын хэлбэлзэл өсч, тогтворгүй болдог.

Өвөлдөө -20 хэм хүйтэрч, зундаа +30 хэм хүртэл халдаг. Үнэмлэхүй хамгийн их температур +40 хэм, үнэмлэхүй хамгийн бага температур -37 хэм хүрнэ.

Хур тунадас ихтэй жилийн нийлбэр хэмжээ нь 371,8 мм.

Нарны нийлбэр цацраг 1200 квт цаг/км$^2$. Чийглэг зуны давтагдал 25%, гангийн давтагдал 20% орчим, хүчтэй салхи 10-аас цөөн өдөр, цасан шуурга 5-аас цөөн өдөр, шороон шуурга 10-аас цөөн өдөр болно.

Салхины зүг чиг, хүч улирлаас хамаарч янз бүр байх боловч ихэвчлэн Баруун-Хойд зүгийн салхитай.

Цасан бүрхүүлийн дундаж зузаан нь 5 см, хамгийн их үедээ 25 см байдаг. Улирлын цэвдэгшил харьцангуй их, ялангуяа өндөрлөг газруудын ар хэсгээр илүү байдаг. Гүн нь 4-10 метр.

### *2.2.1. Агаарын даралт:*

Станцын түвшин дэх агаарын даралтын сарын дундаж утга 869.0-869.1 г/Па, хамгийн их даралт нь 891.0-891.5 г/Па, хамгийн бага нь 850.9- 851.3. г/Па хооронд хэлбэлздэг.

### *2.2.2. Агаарын температур:*

Агаарын температурын олон жилийн дундаж 0,8 С, агаарын температурын хамгийн их утга нь 1999 онд 39.0 С хүрч халсан, агаарын температурын хамгийн бага утга нь 2001 онд – 40.0 С хүрч хүйтэрсэн байна.

### *2.2.3. Агаарын чийгшил:*

Харьцангуй чийгийн олон жилийн дундаж нь 62% байна.

### *2.2.4. Хур тунадас:*

Жилийн нийлбэр тунадасны олон жилийн дундаж нь 360,7 мм ба үүнээс дулааны улиралд 326,3 мм, хүйтний улиралд 34,4 мм нь ордог байна. Хамгийн их тунадас нь 2012 оны 7-р сард 274,6 мм тунадас орсон байна.

## *2.3. Гадаргын ба газрын доорх усны өнөөгийн төлөв байдал*

Орхон аймаг нь Хойд мөсөн далайн ай савд багтдаг. Гадаргын болон гүний усны нөөц харьцангуй багатай.

Аймгийн хэмжээнд нийт 11 гол горхи тоологдсоноос 2 нь усгүй, 40 булаг шанд тоологдсоноос 10 нь ширгэсэн, 4 нуур, цөөрөм тоологдсоноос 1 нь усгүй болсон байна. Томоохонд тооцогдох гол байхгүй бөгөөд Хангал гол хэмээх жижгэвтэр ганц гол байх ба бусад гол болох Чингэлийн гол, Говилын гол, Уртбулаг, Хаяа булаг, Тал булаг, Цагаанчулуут зэрэг гол горхи нь Хангал голд цутган 56 км орчим урсан Орхон голд цутгадаг.

Орхон аймагт Говилын гол дагуу 4, Цагаанчулуутын гол дагуу 3, Чингэлийн гол дагуу 11 газрын доорх усны нөөц бүхий орд тогтоосон байдаг.

## *2.4. Хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдал*

Эрдэнэт хот орчмын нутаг нь хөрсөн бүрхэвчийн хувьд уулын хар хүрэн ба уулын хээрийн хүрэн, нугын бараан хөрс зонхилох боловч боловч олон хэв шинжийн хөрс тархсан байдаг. Тухайлбал уулын арын ой модтой газраар ойн бараан, тайгын ширэгт хөрс, арай нам хэсгээр зузаан давхаргатай хар хүрэн, хөр шороон хөрстэй байхад нам хэсгээр шаварлаг хөрш, нутаг-хар шороон ба нугат-хар хүрэн хөрстэй. Харин Хангал голын дэнж, түүний нарийн салбар ам, хөндийгөөр нугын болон нугат-намгийн хөрс ажиглагддаг.

Хөрсний улирлын хөлдөлт дунджаар 10 дугаар сарын 15-нд эхлэж, 4 дүгээр сарын 3-наас гэсэж эхлэх ба хөлдөлтийн гүн нь элсэнцэр, шавранцар хөрсөндөө дунджаар 2,8-3,5 м байдаг.

### *2.5. Ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал*

Евразийн хээр, Монголын хээрийн муж, Орхон-Сэлэнгийн дэд мужид багтана.

Орхон аймагт нийт 17792 га талбайд ой модны тархац бий. Сибир шинэс, хус, улиангар голлож ургана.

Аймгийн хэмжээнд 46 овгийн 154 төрөлд хамаарах 235 зүйл ургамалтай. Эдгээр зүүлүүдийн дотор мод 7 зүйл, сөөг 12, сөөгөнцөр 2, заримдаг сөөг 5, олон наст өвс 194, нэг ба хоёр наст ургамал 15 зүйл тус тус байна. Мөн Монгол орны унаган ургамал 9 зүйл, эмийн ургамал 26 зүйл, хүнсний (жимс болон цайны) 10 зүйл ургамал тохиолдоно.

### *2.6. Амьтны аймгийн өнөөгийн төлөв байдал*

Орон нутагт 41 зүйлийн хөхтөн амьтан, 2 зүйл хоёр нутагтан бүртгэгдсэн байна. Тэдгээрээс мөлхөгчдийн 4 зүйл, шувууны 124 зүйл, загасны 5 зүйл, шавжийн 215 зүйл тархан амьдарч байна.

### *2.7. Орхон аймгийн Засаг захиргааны нэгж, түүний удирдлага*

Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэгч Аймгийн Засаг дарга нь хотын захирагчийн үүргийг давхар гүйцэтгэдэг бөгөөд 6 хэлтэс бүхий аймгийн Засаг даргын Тамгын газар, Хотын захирагчийн алба, Эрдэнэт ус, ДТС ОНӨХК, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хот тохижуулах газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, Онцгой байдлын газар зэрэг 50 гаруй байгууллага, агентлагаар дамжуулан төрийн үйлчилгээг иргэддээ хүргэж байна.

### *2.8. Нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал*

Орхон аймаг нь Монгол улсын төсвийн орлогын 7,5 хувь, нийт экспортын 10 хувийг дангаараа бүрдүүлдэг.

2020 оны 12 дугаар сарын байдлаар хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн санд Орхон аймгийн харьяат 108.7 мянган хүн 28.6 мянган өрхөд бүртгэлтэй байсан бол 2024 оны байдлаар 104,412 хүн амтай болсон.

Суурин хүн амын 59.7 хувь нь 16-59 насныхан, 32.5 хувь нь 015 насныхан, 7.8 хувь нь 60 ба түүнээс дээш насныхан байна.

Орхон аймаг нь Улаанбаатар, Дархан, Сүхбаатар хотуудтай төмөр замаар,

Улаанбаатар, Дархан, Сүхбаатар, Булган, Мөрөн хотуудтай хатуу хучилттай замаар холбогдсон.

Тус аймагт 128,0 мянган толгой мал бүхий мал аж ахуй, 30-аад байгууллага газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байна.

Эдийн засгийн голлох салбар нь Уул уурхайн олборлох үйлдвэр юм. Жилдээ 1,2 сая метр хивс үйлдвэрлэдэг Эрдэнэт хивс, 3600 тн катодын зэс үйлдвэрлэдэг Эрдмин, Ачих Ихт, Зэс эрдэний хувь зэрэг томоохон үйлдвэрүүдтэй.

869 худалдааны цэг, салбарууд үйл ажиллагаагаа явуулж байна. Нийтдээ 1000 гаруй суудалтай соёлын ордон, театр, соёлын төв, хуримын ордон, хүүхэд залуучуудын төв иргэдэд үйлчилж байна.

### *2.9. Түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдал*

Төслийн талбайд түүх соёлын өв илэрвэл Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуульд заасны дагуу мэргэжлийн байгууллагад хандан судалгаа, шинжилгээ, малталтын дүн болон палеонтологи, археологийн олдворыг сумын захиргаанд тайлагнана. Сумын засаг дарга нь судалгаа, хайгуул, малталт хийсэн газрыг хариуцна. Тэдгээр түүх, шинжлэх ухаан, соёлын үнэт зүйл болох газар, хөрс нь улсын хамгаалалтад байх бөгөөд олдвор нь улсын өмч болдог.

## 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

### *3.1. Газрын гадарга, хэвлий:*

Усан хангамж болон бохирын шугам сүлжээг шинэчлэх, үерийн хамгаалалтын суваг, үерийн ус хуримтлуулах байгууламж барьж байгуулах төслийн үйл ажиллагаанаас газрын газрын гадаргын эвдрэл, элэгдэл, хонхор орон зай үүснэ.

Тус талбай нь барьж байгуулах ажлын хугацаанд эвдэгдэх ба барьж байгуулах ажил дууссаны дараагаар нөхөн сэргээлт хийж, орчны тохижилтын ажлыг хийснээр ашиглалтын үед үүсэх сөрөг бага болно.

### *3.2. Агаарын чанар:*

Усан хангамж болон бохирын шугам сүлжээг шинэчлэх, үерийн хамгаалалтын суваг, үерийн ус хуримтлуулах байгууламж барьж байгуулах төслийн үйл ажиллагаанаас газар ухах үйл ажиллагаа болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, барилгын материалыг хураах талбай болон газар шорооны ажлаас гарсан овоолго зэргээс агаарт тоосжилт үүснэ.

Дээрх үйл ажиллагаа нь ажлын талбар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний маршрутын дагуу явагдаж нөлөөлөл нь хязгаарлагдмал орон зайд, богино хугацаанд байх боломжтой

### *3.3. Гадаргын ус:*

Төслийн үйл ажиллагаанаас сайруудад бетон хоолой тавих, бетонон гаргалгаа хийх, бетонон бэхэлгээтэй хана хийх үед гадаргын урсацаар дамжин барилгын материал, хог хаягдал, шороо, цемент зэрэг нь зөөгдөж гол руу орж

булингар, бохирдол үүсгэх, тээврийн хэрэгслээс шатах тослох материал /ШТМ/ асгарснаас хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын усыг бохирдуулах сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй.

Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулахын тулд усны суваг дотор болон ойр орчимд ажиллахдаа барилгын материалыг гадаргын болон ус зайлуулах сувгаас усны урсацад өртөхөөргүй зайд байрлуулах, ШТМ асгарсан тохиолдолд тархахаас сэргийлж зориулалтын шингээгч материал (spill kit)-ыг тээврийн хэрэгслүүдэд болон бусад шаардлагатай газруудад бэлэн байлгах, цаг агаарын аюултай үзэгдлийн болон борооны урьдчилсан мэдээг тогтмол ашиглаж ажлаа зохион байгуулж үер усны аюулаас сэрэмжлэх, зураг төслийн шатанд хийсэн их урсацын нарийвчилсан тооцоог барьж байгуулахад ашиглаж үерийн хамгаалалтын байгууламжийг найдвартай байх, тогтвортой ашиглах нөхцөлийг хангах хэрэгтэй.

### *3.4. Газар доорх ус:*

Усан хангамж болон бохирын шугам сүлжээг шинэчлэх, үерийн хамгаалалтын суваг, үерийн ус хуримтлуулах байгууламж барьж байгуулах үед газар доорх усанд үзүүлэх нөлөөлөл бага байна.

### *3.5. Хөрсөн бүрхэвч:*

Усан хангамж болон бохирын шугам сүлжээг шинэчлэх, үерийн хамгаалалтын суваг, үерийн ус хуримтлуулах байгууламж барьж байгуулах үед талбайн хөрс элэгдэж, эвдрэн хуулагдах ба энэхүү хуулагдаж овоолгод нөөцөлсөн шимт хөрсийг барьж байгуулах ажил дууссаны дараагаар эвдэрсэн талбайг хучин нөхөн сэргээхэд болон орчныг тохижуулахад ашиглана.

### *3.6. Ургамлан нөмрөг:*

Усан хангамж болон бохирын шугам сүлжээг шинэчлэх, үерийн хамгаалалтын суваг, үерийн ус хуримтлуулах байгууламж барьж байгуулах үед өнгөн хөрстэй хамт ургамлан бүрхэвч хуулагдана. Шимт хөрсний овоолго болон ухмалаас гарсан шороон доор ургамлан бүрхэвч дарагдана.

### *3.7. Амьтны аймаг:*

Төслийн талбай нь хот суурины газар учир амьтны аймгийн томоохон төлөөлөгч байхгүй, харин шувуу, сээр нуруугүйтэн амьтад дунд зэрэг тархалттай тул амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага юм.

Усан хангамж болон бохирын шугам сүлжээг шинэчлэх, үерийн хамгаалалтын суваг, үерийн ус хуримтлуулах байгууламж барьж байгуулах үед газар хөндөлтийн өмнө нүхэнд амьдардаг амьтад машин техник төхөөрөмжид өртөх, түүнчлэн ухсан нүх, шуудуу зэрэгт ойр орчмын мал, амьтан унаж эрсдэх нөлөөлөл үүсэж болзошгүй.

Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулахын тулд мал, амьтад унахаас урьдчилан сэргийлж, газар хөндөлтийн өмнө амьтад өртөх эсэхийг шалгаж, мал, амьтдыг эрсдэх орчноос холдуулах, ухсан нүх, шуудуу зэрэгт хамгаалалтын хил хүрээ татаж хамгаалах, гэрэл ойлгогч бүхий тэмдэг, тэмдэглэгээ хийх, анхааруулсан тэмдэг харагдахуйцаар байрлуулах хэрэгтэй.

### *3.8. Нийгэм, эдийн засаг:*

Усан хангамж болон бохирын шугам сүлжээг шинэчлэх, үерийн хамгаалалтын суваг, үерийн ус хуримтлуулах байгууламж барьж байгуулах үед нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй, харин ашиглалтын үед айл өрхийн усан хангамж сайжрах, өдөр бүр 50 хүртэл удаа ус тээвэрлэх ажиллагаа зогссоны үр дүнд нүүрстөрөгчийн ялгарлыг арилгана, нэгдсэн хэрэглээний халуун усыг сургууль, цэцэрлэгт холбож, орчин нөхцөл нь сайжирснаар тогтвортой хөгжлийн асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэхэд түлхэц болно.

***3.9. Тусгай хамгаалалттай газар нутаг:***

Эрдэнэт хотод хэрэгжиж буй “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” буюу бохир, цэвэр усны шугам сүлжээг төвийн шугамд холбох, үерийн хамгаалалтын байгууламжийг сайжруулах төслийн үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутагт сөрөг нөлөөлөл үүсэхээргүй байна.

# 4. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

***4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт***

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг тогтооход оршино.

“Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн үерийн хамгаалалтын суваг, үерийн ус хуримтлуулах байгууламж, ус хангамжийн болон бохирын шугам хоолойг барьж байгуулах ажлын үед төслийг хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч нар мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол улсын хууль, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал, төсөл хэрэгжих газарт хийсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам зэрэгт үндэслэн боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдсэн.

## 4.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

<table>
<tr><th>Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд</th><th>Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ</th><th>Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ</th><th>Хэмж их нэгж</th><th>Нэгжийн зардал (төгрөг)</th><th>Тоо хэмжээ</th><th>Нийт зардал, төг</th><th>Хэрэгжүүлэх хугацаа, давтамж</th><th>Баримтлах эрх зүйн баримт бичиг</th></tr>
<tr><td colspan="9">4.2.1. Агаар</td></tr>
<tr><td rowspan="5">Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой барих үед тоосжилт үүсэх</td><td>Халуун хуурай үед тоос босож буй зам, ил шороон талбайтай хэсгийг услах (1 $м^2$ газарт 2 л гэсэн нормын дагуу)</td><td>Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим</td><td>Төг/л</td><td>1 $м^2$ усны өртөг 1600 төг</td><td>299400 $м^2$</td><td>958,080.0</td><td>Тоосжилт ихэссэн тохиолдлоос хамаарч нэмэгдэж болно.</td><td rowspan="5">Агаарын бохирдлын тухай хууль,<br><br>MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага</td></tr>
<tr><td>Ухмалаас гарсан түр овоолгын шороо салхинд хийсэхээс сэргийлж хугацаа алдалгүй тэгшилж нөхөн сэргээлт хийх</td><td>Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим</td><td colspan="4">Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан.</td><td>2025-2026 онд</td></tr>
<tr><td>Барилгын материал, элс, шавар, цемент зэргийг тохиромжтой газар байрлуулах, салхинд хийсэж тоосжилт үүсгэхээс сэргийлэх</td><td>Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>2025-2026 онд</td></tr>
<tr><td>Ажлын талбайд шороон замд автомашины хурдыг багасгаж хязгаарлалт тогтоох</td><td>Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой, тээврийн шороон зам орчим</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>2025-2026 онд</td></tr>
<tr><td>Нурмаг ачаа хучлагатай тээвэрлэх</td><td>Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>2025-2026 онд</td></tr>
</table>

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хоолой, тээврийн шороон зам орчим | | | | | | |
| Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой барьж байгуулах үед дуу шуугиан зөвшөөрөгдөх түвшнээс ихсэх | Зохих стандартад зөвшөөрөгдөх түвшний дуу шуугиан, чичиргээг үүсгэдэг эсвэл дуу шуугианыг бууруулагч төхөөрөмжөөр тоноглогдсон машин механизм, тоног төхөөрөмжийг авч ажиллуулах | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | - | - | - | - | 2025-2026 онд | |
| | Тээврийн хэрэгслийн дуу шуугианы ялгаруулалтын байнгын хяналт шалгалт, засвар үйлчилгээг хийх | Нийт тээврийн хэрэгслүүд | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2024-2026 онд тогтмол | |
| | Хэт их дуу шуугиантай байвал дуу намсгагч хэрэглэх, шөнийн цагаар ажиллахгүй байх | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2026 онд тогтмол | |
| Агаарт хорт хий ялгаран агаарын чанарт нөлөөлөх | Машин механизм, тоног Төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх | Нийт тээврийн хэрэгслүүд | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2026 онд | MNS 4470:2005 Авто тээврийн хэрэгслийн хэрэглээний үзүүлэлтүүд. Ангилал, Ерөнхий шаардлага |
| | Машин механизмын асаалттай сул зогсолтыг хориглох, ажилчдад сануулах | Нийт тээврийн хэрэгслүүд | - | | | | 2025-2026 онд | |

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нөхөн сэргээлт муу хийсэн газраас тоос босож орчин тоосжих | Нөхөн сэргээлт муу хийгдсэн газруудад нөхөн сэргээлт дахин хийж тоосжилт үүсэхээргүй болгох | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2026 онд | |
| **Нийт зардал** | | | **958,080.0 төгрөг** | | | | | |
| ***4.2.2. Газрын гадарга хэвлий*** | | | | | | | | |
| Газрын хэвлийд хонхор орон зай үүсэх | Эвдэрсэн газрын гадаргыг хуучин төрхөд нь буцаан оруулж, аюул осолгүй болгож, цаашид ашиглаж болохуйцаар нөхөн сэргээх | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан | | | | 2025-2026 онд | MNS 17.5.1.19-92 Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага |
| Газрын гадарга хог хаягдлаар бохирдох | Барьж байгуулах үед үүссэн хог хаягдал болон ахуйн элдэв хог хаягдал, бусад бохирдуулагч эх үүсвэрүүдийг зохих шаардлага, журмын дагуу хадгалах буюу устгах | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан | | | | 2025-2026 онд | Хог хаягдлын тухай хууль |
| Ашиглалтын үед орчны газрын гадарга эвдрэх | Үерийн хамгаалалтын сувагт үзлэг, цэвэрлэгээ, засварын ажлыг хийж бөглөрөх, үерийн ус халих, улмаар орчны | Үерийн хамгаалалтын суваг | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2027 онд | |

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын гадарга эвдрэхээс сэргийлэх | | | | | | | |
| | Ус хуримтлуулах байгууламжид үзлэг, цэвэрлэгээ хийх, засварын ажлыг тогтмол хийж болзошгүй эрсдэл, байгууламжаас дооших газрын гадарга эвдрэхээс сэргийлэх | Ус хуримтлуулах байгууламж | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2026 онд | |
| | Шугам сүлжээний ажлын дараа дүүргэлт, нөхөн сэргээлтийг чанартай хийж, нүх үүсэж осол эрсдэл гарахаас сэргийлэх | Шугам сүлжээний ажил хийсэн газар | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2026 онд | |
| ***4.2.3. Усан орчин*** | | | | | | | | |
| Гадаргын урсацаар дамжин барилгын материал, хог хаягдал, шороо, цемент зэрэг нь зөөгдөж гол руу | Барилгын материал болон хог хаягдлыг сайр болон үерийн усны сувгаас хамгийн багадаа 100 м зайд байрлуулах | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2026 онд | Усны тухай хууль |

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмж их нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал , төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| орж булингар, бохирдол үүсгэх | | | | | | | | |
| Цаг агаарын аюултай үзэгдлийн нөлөөнөөс барьж дуусаагүй байгаа суваг, байгууламж эвдрэх | Цаг агаарын аюултай үзэгдлийн болон борооны урьдчилсан мэдээг тогтмол ашиглаж ажлаа зохион байгуулах | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2026 онд | |
| Тээврийн хэрэгслээс шатах тослох материал /ШТМ/ асгарснаас хур тунадасны усаар дамжин гадаргын ус болон газар доорх усыг бохирдуулах | ШТМ асгарсан тохиолдолд хөрсөнд тархаж, улмаар усан орчин бохирдохоос сэргийлж зориулалтын шингээгч материал зэргийг шаардлагатай газруудад бэлэн байлгах | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | Энэ төлөвлөгөөний хөрсний хэсэгт тусгав | | | | 2025-2026 онд | MNS 5850-2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис,элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| | Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хөрс болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй тусгай орчинд явуулах | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж болон ус хангамжийн шугам хоолой орчим | - | - | - | - | 2025-2026 онд | |
| Усны хэрэглээг хяналтгүй зарцуулснаар усан хангамжийн | Баян-Өндөр сумын Хот тохижуулах газартай усны хэрэглээний гэрээ хийж ажиллах | Хот тохижуулах газар, барилгын ажил гүйцэтгэгч компани | ---*--- | | | | 2025-2026 онд | Усны тухай хууль |

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| газар доорх усны нөөцөд нөлөө үүсэж болзошгүй. | | | | | | | | |
| Усны нөөц хомсдох | Барьж байгуулах ажилд хэрэглэх усны хэмжээг гэрээ болон төсөвт тусгаснаас хэтрүүлэлгүй байлгаж, усны хэрэглээг хяналттай байлгах | Нийт усны хэрэглээ | ---*--- | | | | 2025-2026 онд | Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм |
| Бие засах газар, бохир шингэний сав зэргээс хөрс, газар доорх ус бохирдох | Стандартын шаардлага хангасан жорлон, бохирын сав зэргийг ашиглаж, соруулж ариутгах татуургад нийлүүлэх ажлыг гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэх | Түр кемп | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав | | | | 2025-2026 онд | |
| Ашиглалтын үед орчин үерт автах | Үерийн урсацад хяналт тавьж байх, суваг, байгууламжийн нэвтрүүлэлт, бүрэн бүтэн байдал, шүүрэл зэрэгт тогтмол хяналт тавьж, хийцийг сайжруулах арга хэмжээ авч байх | Үерийн хамгаалалтын суваг, байгууламж орчим | Үйл ажиллагааны зардлаас | | | | 2025-2026 онд | |

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
